

**БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГЫГ СОНГОХ ТУХАЙ АСУУДЛААР ТӨРИЙН  
БАЙГУУЛАЛТЫН БАЙНГЫН ХОРООНООС ГАРГАСАН САНАЛ, ДҮГНЭЛТ**

2014 оны 12 дугаар  
сарын 23-ны өдөр

Улаанбаатар  
хот

**Илтгэгч нь: Улсын Их  
Хурлын гишүүн Су.Батболд**

Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Төрийн байгуулалтын байнгын хорооны даргыг сонгох асуудлыг Байнгын хороо 2014 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн хуралдаанаараа хэлэлцээд дараах санал, дүгнэлтийг нэгдсэн хуралдаанд танилцуулж байна.

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.6, мөн хуулийн 22 дугаар зүйлийн 22.4, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1 дэх хэсэгт заасныг баримтлан Байнгын хорооны даргыг сонгох асуудлыг хэлэлцлээ.

Улсын Их Хурлын гишүүн Д.Эрдэнэбат Төрийн байгуулалтын байнгын хорооны даргад Улсын Их Хурлын гишүүн Агипарын Бакейг улируулан ажиллуулахаар нэр дэвшүүлснийг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжив.

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн А.Бакей, Д.Лүндээжанцан, Л.Цог нар эрх ашгийн эрэмбийг баримтлан зөвшилцөл, ойлголцлыг зохицуулж, цөөнх гэлтгүй бүгдийнх нь эрх ашгийг ханган ажиллах, намын бодлого гэхээсээ илүүтэй мэргэшсэн хүмүүсийн үзэл бодлыг сонсох, Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт оруулах ажлыг эрчимжүүлэх, төрийн албаны шинэчлэлтэй холбоотой асуудлыг шийдвэрлэх зөв гарцыг олж ирээдүйн хөгжлийн эрх ашгийн төлөө хамтарч ажиллах нь зүйтэй талаар саналаа илэрхийлэв.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Улсын Их Хурлын гишүүн А.Бакейг Төрийн байгуулалтын байнгын хорооны даргаар сонгох асуудлаар Байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг Та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

**ХУРАЛДААН ДАРГАЛАГЧ  
УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН**

**СУ.БАТБОЛД**

